



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/635

Есөнбулаг

Газар эзэмших эрхийн дуудлага
худалдаа зохион байгуулах ажлын
хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024 оны А/391, А/605 дугаар захирамжаар зарлагдсан газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Гаадамба (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүдэд: П.Золбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ж.Мөнхчимэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, ерөнхий архитектор)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхтуяа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, шалгаруулалтын үр дүнг танилцуулахыг комисс (Д.Гаадамба)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Л.Хац-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ